



## ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

### САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Өмнөговь аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код:** ӨМА-2026/091/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: <a href="http://www.Umnugovi@audit.mn">www.Umnugovi@audit.mn</a> Өмнөговь аймаг  2026 он</p>	<p>Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Ц.Өсөхбаяр Утас: 70533539 Цахим хаяг: usukhbayarts@audit.gov.mn Аудитын менежер: Т.Хонгорзул Утас: 70533552 Цахим хаяг: Khongorzult@audit.gov.mn Ахлах аудитор: Г.Шижирболд Утас: 70533552 Цахим хаяг: Shijirboldg@audit.gov.mn Аудитор: Ө.Болортуяа Утас: 70533552 Цахим хаяг: Bolortuyau@audit.gov.mn</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

<b>1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ</b> .....	2
<b>2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ</b> .....	4
<b>2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан</b> .....	4
<b>2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан</b> .....	4
<b>2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан</b> .....	6
<b>2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан</b> .....	7
<b>2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан</b> .....	7
<b>2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан</b> .....	8
<b>5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ</b> .....	9
<b>5.1 Төлбөрийн акт</b> .....	9
<b>5.1 Албан шаардлага</b> .....	10
<b>5.2 Зөвлөмж</b> .....	12
<b>6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ</b> .....	13

**Товчилсон үгийн жагсаалт**

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
ЗГНХ	Засгийн газрын нөөц хөрөнгө
ЗДНХ	Засаг даргын нөөц хөрөнгө

## 1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



### ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон 304 тоот, 3 дугаар баг,  
Даланзадгад сум, Өмнөговь аймаг, 46083  
Утас: (976) 7053 3539, Цахим хуудас: www.audit.mn  
Цахим шуудан: umnogovi@audit.gov.mn

2026.02.25 № 251

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ИРГЭДИЙН  
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА  
Б.БАТДОРЖ ТАНАА

### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Өмнөговь аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

### Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Худалдан авах ажиллагаа зохион байгуулалгүйгээр 15,614.9 мянган төгрөгийн шууд гэрээ байгуулсан, 3,251.6 мянган төгрөгийн эзлжийн амралтын олговор, 3,450.0 мянган төгрөгийн хоолны нэмэгдлийг давхардуулан олгосон, 478,136.4 мянган төгрөгийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчдийг гадаад улсад туршлага судлах сургалтад хамруулсан үр дүн нь баримтаар нотлогдохгүй зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна.

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 16 дугаар зүйлийн 16.5.5, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1, 35 дугаар зүйлийн 35.2, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 13 дугаар зүйлийн 13.1 дахь заалт, Монгол улсын Ерөнхий сайдын 2025 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн "Төсвийн сахилга бат, хариуцлагыг чангатгах" 05 албан даалгавартай тус тус нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлангийн үнэн зөв байх, нийцсэн бөгөөд зохистой байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

4626050405

#### **Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Аймаг, сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгч болон ажлын албаны албан хаагчдыг чадавхжуулах сургалтыг Удирдлагын академи, хуулийн ферм, төрийн бус байгууллагуудтай хамтран нэгдсэн болон бүсчилсэн байдлаар зохион байгуулсан байна.

#### **Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Улсын хэмжээнд зохион байгуулагдсан архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэг хамрагдан нийлбэр үнэлгээгээр 90.9 хувьтай дүгнэгдсэн байна.

#### **Бусад асуудлын хэсэг**

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 зорилтын хүрээнд 71 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийг 82 хувийн гүйцэтгэлтэй дүгнүүлсэн байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

#### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ӨСӨХБАЯР

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	27,482,677.34	35,325,853.80
33	АВЛАГА	-	655,576.46
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	655,576.46
35	БАРАА МАТЕРИАЛ	27,482,677.34	34,670,277.34
354	Хангамжийн материал	27,482,677.34	34,670,277.34
35410	Бичиг хэргийн материал	3,479,500.00	-
35420	Аж ахуйн материал	1,649,890.00	1,536,990.00
35440	Түлш, шатах тослох материал	8,040,000.00	18,820,000.00
35470	Бусад хангамжийн материал	14,313,287.34	14,313,287.34
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,014,607,697.93	888,166,702.96
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,014,607,697.93	888,166,702.96
392	Биет хөрөнгө	1,014,387,697.77	888,056,702.78
39203	Авто-тээврийн хэрэгсэл	360,580,300.00	360,580,300.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(214,241,667.04)	(259,314,204.61)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	950,776,143.00	1,035,275,043.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(215,426,181.85)	(359,879,208.62)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	102,755,525.00	105,134,525.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(21,436,629.43)	(29,885,585.02)
39214	Бусад үндсэн хөрөнгө	102,500,000.00	102,500,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(51,119,791.91)	(66,354,166.97)
393	Биет бус хөрөнгө	220,000.16	110,000.18
39301	Программ хангамж	5,500,000.00	1,100,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(5,279,999.84)	(989,999.82)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,042,090,375.27	923,492,556.76
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,042,090,375.27	923,492,556.76
51	Засгийн газрын хувь оролцоо	1,042,090,375.27	923,492,556.76
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	174,867,941.66	174,867,941.66
51101	Өмч: - төрийн	174,867,941.66	174,867,941.66
512	Хуримтлагдсан үр дүн	866,957,863.61	748,360,045.10
51210	Өмнөх үеийн үр дүн	866,957,863.61	866,957,863.61
51220	Тайлант үеийн үр дүн	-	(118,597,818.51)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	264,570.00	264,570.00
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,042,090,375.27	923,492,556.76

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	3,351,893,070.00	3,799,720,020.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	75,270,300.00	78,910,000.00-
120	Нийтлэг татварын бус орлого	34,810,000.00	-
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	34,810,000.00	-
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	34,810,000.00	-
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-ҮХ	38,680,300.00	76,700,000.00

**Өмнөговь аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд хийсэн аудитын тайлан**

1200018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-БМ	1,780,000.00	2,210,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,276,622,770.00	3,720,810,020.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	563,532,370.00	109,143,770.00
131103	ЗГНХ, ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	42,532,370.00	68,143,770.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	521,000,000.00	41,000,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	2,713,090,400.00	3,611,666,250.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	2,713,090,400.00	3,611,666,250.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	3,522,362,214.80	3,918,317,838.51
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,522,362,214.80	3,918,317,838.51
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,832,590,159.15	2,895,910,594.60
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	589,452,509.48	776,573,872.89
210101	Үндсэн цалин	276,118,478.69	258,531,051.27
210102	Нэмэгдэл	218,295,880.79	271,246,206.45
210103	Унаа хоолны хөнгөлөлт	45,348,000.00	151,668,012.07
210104	Урамшуулал	49,690,150.00	95,128,603.10
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	74,877,726.49	98,768,186.74
210201	Тэтгэврийн даатгал	51,968,775.78	67,041,519.15
210202	Тэтгэмжийн даатгал	5,997,830.11	8,841,092.68
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,173,095.09	3,982,381.21
210204	Ажилгүйдлийн даатгал	1,656,462.41	3,646,144.66
210205	Эрүүл мэндийн даатгал	12,081,563.10	15,257,049.04
2104	Хангамж, бараа материалын зардал	79,127,884.49	88,483,205.00
210401	Бичиг хэрэг	10,675,350.00	10,176,800.00
210402	Тээвэр, шатахуун	53,350,000.00	69,230,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,626,044.49	4,639,505.00
210404	Ном, хэвлэл	2,892,800.00	2,350,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,583,690.00	2,086,900.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	55,813,300.00	53,526,900.00
210604	Урсгал засвар	55,813,300.00	53,526,900.00
2107	Томилолт, зочны зардал	5,066,000.00	15,840,000.00
210702	Дотоод албан томилолт	5,066,000.00	15,840,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	610,755,680.00	247,536,680.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	610,755,680.00	247,536,680.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,417,497,058.69	1,615,181,749.97
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	615,610,400.00	924,316,760.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	520,391,260.00	472,109,095.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	281,495,398.69	218,755,894.97
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	689,772,055.65	1,022,407,243.91
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	286,400,000.00	847,533,915.00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	286,400,000.00	847,533,915.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	117,469,000.00	54,156,500.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	-	22,488,500.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	52,104,000.00	-
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	29,730,000.00	17,213,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	35,635,000.00	14,455,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	120,716,828.91
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	120,716,828.91
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	285,903,055.65	-
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	285,903,055.65	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-170,469,144.80	-118,597,818.51
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-170,469,144.80	-118,597,818.51

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>3,276,622,770.00</u>	<u>3,720,810,020.00</u>
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,276,622,770.00	3,720,810,020.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	563,532,370.00	109,143,770.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	42,532,370.00	68,143,770.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	521,000,000.00	41,000,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	2,713,090,400.00	3,611,666,250.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	2,713,090,400.00	3,611,666,250.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>3,204,565,935.00</u>	<u>3,705,195,120.00</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,204,565,935.00	3,705,195,120.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,514,793,879.35	2,681,787,876.09
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	560,305,968.37	777,229,449.35
210101	Үндсэн цалин	246,971,937.58	259,186,627.73
210102	Нэмэгдэл	218,295,880.79	271,246,206.45
210103	Унаа хоолны хөнгөлөлт	45,348,000.00	151,668,012.07
210104	Урамшуулал	49,690,150.00	95,128,603.10
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	74,877,726.49	98,768,186.74
210201	Тэтгэврийн даатгал	51,968,775.78	67,041,519.15
210202	Тэтгэмжийн даатгал	5,997,830.11	8,841,092.68
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,173,095.09	3,982,381.21
210204	Ажилгүйдлийн даатгал	1,656,462.41	3,646,144.66
210205	Эрүүл мэндийн даатгал	12,081,563.10	15,257,049.04
2104	Хангамж, бараа материалын зардал	71,973,544.49	86,460,805.00
210401	Бичиг хэрэг	8,459,700.00	6,697,300.00
210402	Тээвэр, шатахуун	55,000,000.00	71,000,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,626,044.49	4,639,505.00
210404	Ном, хэвлэл	2,892,800.00	2,350,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	995,000.00	1,774,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	55,813,300.00	53,526,900.00
210604	Урсгал засвар	55,813,300.00	53,526,900.00
2107	Томилолт, зочны зардал	5,066,000.00	15,840,000.00
210702	Дотоод албан томилолт	5,066,000.00	15,840,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	610,755,680.00	247,536,680.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	610,755,680.00	247,536,680.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,136,001,660.00	1,402,425,855.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	615,610,400.00	930,316,760.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	520,391,260.00	472,109,095.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	689,772,055.65	1,023,407,243.91
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	286,400,000.00	847,533,915.00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	286,400,000.00	847,533,915.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	117,469,000.00	55,156,500.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	-	22,488,500.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	52,104,000.00	-

**Өмнөговь аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд хийсэн аудитын тайлан**

213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	29,730,000.00	17,213,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	35,635,000.00	15,455,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	120,716,828.91
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	120,716,828.91
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	285,903,055.65	-
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	285,903,055.65	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>72,056,835.00</u>	<u>15,614,900.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	72,056,835.00	15,614,900.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	72,056,835.00	15,614,900.00
2200	Дотоод эх үүсвэрээр	72,056,835.00	15,614,900.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	72,056,835.00	15,614,900.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(72,056,835.00)</u>	<u>(15,614,900.00)</u>

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцоо	Дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан үр дүн	Нийт дүн
1	2024 оны 12-р сарын 31-ээр үлдэгдэл	174,867,941.66	264,570.00	866,957,863.61	1,042,090,375.27
2	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	174,867,941.66	264,570.00	866,957,863.61	1,042,090,375.27
3	Тайлант үеийн үр дүн	0	0	-118,597,818.51	-118,597,818.51
4	225 оны 12-р сарын 31-ээр үлдэгдэл	174,867,941.66	264,570.00	748,360,045.10	923,492,556.76

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,857,329,300.00	3,491,113,057.46
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,857,329,300.00	3,491,113,057.46
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,942,040,800.00	2,588,422,642.46
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	860,949,000.00	716,936,062.02
210101	Үндсэн цалин	337,000,000.00	259,186,627.73
210102	Нэмэгдэл	260,000,000.00	271,246,206.45
210103	Унаа хоолны хөнгөлөлт	204,000,000.00	151,668,012.07
210104	Урамшуулал	59,949,000.00	34,835,215.77
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	107,618,600.00	91,081,440.44
210201	Тэтгэврийн даатгал	73,180,700.00	62,643,623.30
210202	Тэтгэмжийн даатгал	8,609,500.00	7,397,061.90
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,304,700.00	3,506,792.53
210204	Ажилгүйдлийн даатгал	4,304,700.00	3,506,792.53
210205	Эрүүл мэндийн даатгал	17,219,000.00	14,027,170.18
2104	Хангамж, бараа материалын зардал	103,600,000.00	86,460,805.00
210401	Бичиг хэрэг	18,000,000.00	6,697,300.00
210402	Тээвэр, шатахуун	71,000,000.00	71,000,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	9,600,000.00	4,639,505.00

**Өмнөговь аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд хийсэн аудитын тайлан**

210404	Ном, хэвлэл	3,000,000.00	2,350,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,000,000.00	1,774,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	72,000,000.00	69,141,800.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	16,000,000.00	15,614,900.00
210604	Урсгал засвар	56,000,000.00	53,526,900.00
2107	Томилолт, зочны зардал	29,700,000.00	15,840,000.00
210702	Дотоод албан томилолт	29,700,000.00	15,840,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	271,000,000.00	206,536,680.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	271,000,000.00	206,536,680.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,497,173,200.00	1,402,425,855.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	952,497,100.00	930,316,760.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	544,676,100.00	472,109,095.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	915,288,500.00	902,690,415.00
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	850,000,000.00	847,533,915.00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	850,000,000.00	847,533,915.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	65,288,500.00	55,156,500.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	22,488,500.00	22,488,500.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	17,300,000.00	17,213,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	25,500,000.00	15,455,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	15,614,900.00)
2200	Дотоод эх үүсвэрээр	-	15,614,900.00)
223001	Бусад хөрөнгө	-	15,614,900.00)
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>3,857,329,300.00</b>	<b>3,491,113,057.46</b>
1320	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>3,857,329,300.00</b>	<b>3,491,113,057.46</b>
132001	Орон нутгийн төсвөөс	3,857,329,300.00	3,491,113,057.46

**2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан**

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	109,143,770.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	109,143,770.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	108,980,133.63
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	60,293,387.33
210104	Урамшуулал	60,293,387.33
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	7,686,746.30
210201	Тэтгэврийн даатгал	4,397,895.85
210202	Тэтгэмжийн даатгал	1,444,030.78
210203	ҮОМШӨ-ний даатгал	475,588.68
210204	Ажилгүйдлийн даатгал	139,352.13
210205	Эрүүл мэндийн даатгал	1,229,878.86
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	41,000,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	41,000,000.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	163,636.37
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг	163,636.37
II	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>109,143,770.00</b>
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	109,143,770.00
131103	ЗГНХ, ЗДН Хөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	68,143,770.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	41,000,000.00

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 3,857,329.3 мянган төгрөгийн алдаа<sup>1</sup> илэрснээс аудитын явцад тус алдааг залруулсан.

*Залруулсан алдаа:*

- Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болох 3,857,329.3 мянган төгрөгийг дутуу илэрхийлсэн,
- Сангийн сайдын хүчингүй болсон 2006 оны 388 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан маягтаар 2025 оны Санхүүгийн тайланг тайлагнасан.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 1,088,079.8 мянган төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон 35,223.6 мянган төгрөгийн материаллаг байдлын түвшнээс давсан тул "Хязгаарлалттай" дүгнэлт өглөө.

### 5.1 Төлбөрийн акт

**Илрүүлэлт- 1:** Тайлант онд 3,450.0 мянган төгрөгийн хоолны нэмэгдлийг албан томилолтын хоолны зардалтай давхардуулан олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "*төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах*", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "*үнэн зөв байх*", Монгол улсын Ерөнхий сайдын 2025 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн "Төрийн албаны сахилга, дэг журам, хариуцлагыг чангатгах тухай" 03 албан даалгаврын 1.6-д "*Төрийн хэмнэлтийн тухай хуулийн дагуу төсвийн үрэлгэн байдал, хэрэгцээгүй худалдан авалт, гадаад томилолтыг хязгаарлаж, төсвийн хөрөнгөөр олон нийтийн арга хэмжээг зохион байгуулахгүй байх талаар харьяа байгууллага, хуулийн этгээдийн удирдлагад үүрэг өгч, үр дүнг тооцож ажиллах*" гэж заасантай нийцэхгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Давхардуулан олгосон хоолны нэмэгдэл 3,450.0 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр төлбөрийн акт тогтоолоо.

**Илрүүлэлт- 2:** 2025 оны 2-р сард 7 албан хаагчид илүү цагийн нэмэгдэл хөлс олгохдоо нийт 1,157.0 мянган төгрөгийн цалинг илүү тооцож олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "*төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах*", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "*үнэн зөв байх*", Хөдөлмөр, Нийгмийн хамгааллын сайдын 2021 оны А/192 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Дундаж цалин хөлс тодорхойлох журам", Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид нэмэгдэл хөлс олгох журам"-ын 3.3-д "*Илүү цагаар, долоо хоногийн амралтын өдрөөр, нийтээр амрах баяр ёслолын өдрөөр, шөнийн цагаар ажилласны нэмэгдэл хөлс тооцох цаг нь 4.1-т зааснаас бусад тохиолдолд тухайн сарын ажлын цагийн 10 хувиас хэтрэхгүй байна. Тухайлбал, 8 дугаар сарын ажлын цаг 160 гэж үзвэл тухайн сард нэмэгдэл хөлс тооцогдох цаг нь 16-аас илүүгүй байна*" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Илүү тооцож олгосон 1,157.0 мянган төгрөгийг цалинг орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр төлбөрийн акт тогтоолоо.

**Илрүүлэлт- 3:** Тайлант онд 2 албан хаагчид 3,251.6 мянган төгрөгийн ээлжийн амралтын олговрыг цалинтай давхардуулан олгосон байна.

Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 99 дүгээр зүйлийн 99.1-д "*Ажилтанд ажлын жил бүр ээлжийн амралт олгож биеэр эдлүүлнэ. Ажлын зайлшгүй шаардлагаар ээлжийн амралтаа биеэр эдэлж чадаагүй ажилтанд олгох мөнгөн урамшууллын хэмжээг энэ хуулийн 110.2-т заасан хэмжээнээс нэмэгдүүлж олгох асуудлыг хамтын гэрээгээр, хамтын гэрээгүй бол ажилтантай тохиролцон олгоно*", Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны А/191 дүгээр тушаалын хавсралтаар

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

батлагдсан "Ээлжийн амралт олгох, ээлжийн амралтын цалин тооцох журам"-ын 2.8.1-д "ажилтанд ажилласан хугацаанд нь ногдох ээлжийн амралтын цалинг олгох", 2.8.2-д "ажилтнаас илүү олгосон ээлжийн амралтын цалингийн суутгалыг хийх" гэж заасантай нийцэхгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Ээлжийн амралтын олговортой давхардуулан олгосон 3,251.6 мянган төгрөгийг цалинг орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр төлбөрийн акт тогтоолоо.

### 5.1 Албан шаардлага

**Илрүүлэлт 1:** Хичээл үйлдвэрлэлийн зардлыг түүвэрлэн шалгахад 1,395.8 мянган төгрөгийн онгоцны тасалбарын үнэ төлсөн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх", Монгол улсын Ерөнхий сайдын 2025 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн "Төрийн албаны сахилга, дэг журам, хариуцлагыг чангатгах тухай" 03 албан даалгаврын 1.6-д "Төрийн хэмнэлтийн тухай хуулийн дагуу төсвийн үрэлгэн байдал, хэрэгцээгүй худалдан авалт, гадаад томилолтыг хязгаарлаж, төсвийн хөрөнгөөр олон нийтийн арга хэмжээг зохион байгуулахгүй байх талаар харьяа байгууллага, хуулийн этгээдийн удирдлагад үүрэг өгч, үр дүнг тооцож ажиллах" гэж заасантай нийцэхгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Төсвийг үр ашигтай, зориулалтын дагуу зарцуулж ажиллах тухай албан шаардлага хүргүүлсэн.

**Илрүүлэлт 2:** Хичээл үйлдвэрлэлийн зардлыг 544,676.1 мянган төгрөгөөр батлуулан бодит тооцоололгүй, төсөв зарцуулах шийдвэргүйгээр 444,674.1 мянган төгрөг буюу батлагдсан төсвийн 81.6 хувийг хоол, зочид буудлын төлбөрт зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх", Монгол улсын Ерөнхий сайдын 2025 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн "Төрийн албаны сахилга, дэг журам, хариуцлагыг чангатгах тухай" 03 албан даалгаврын 1.6-д "Төрийн хэмнэлтийн тухай хуулийн дагуу төсвийн үрэлгэн байдал, хэрэгцээгүй худалдан авалт, гадаад томилолтыг хязгаарлаж, төсвийн хөрөнгөөр олон нийтийн арга хэмжээг зохион байгуулахгүй байх талаар харьяа байгууллага, хуулийн этгээдийн удирдлагад үүрэг өгч, үр дүнг тооцож ажиллах" гэж заасантай нийцэхгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Төрийн хэмнэлтийн тухай хуульд нийцүүлж төсвийг бодит тооцоололтой, үр ашигтай зарцуулж ажиллах тухай албан шаардлага хүргүүлсэн.

**Илрүүлэлт 3:** Тайлант онд 15,614.9 мянган төгрөгийн хөрөнгө бэлтгэхдээ цахим худалдан авалт хийгээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.4-д "хуульд өөрөөр заагаагүй бол бараа нийлүүлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэх этгээдийг чөлөөт өрсөлдөөн, нээлттэй сонгон шалгаруулалтын аргаар сонгох", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д "Энэ хуулийг хэрэгжүүлэхэд өрсөлдөх тэгш боломжтой, ил тод, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтална", 35 дугаар зүйлийн 35.2-д "Гэрээ шууд байгуулах тухай зарлалыг бараа, ажил, үйлчилгээний ерөнхий мэдээллийн хамт цахим системд нийтэлж, энэ хуулийн 54.8-д зааснаар аж ахуй эрхлэгчид хэлэлцээ хийх урилга хүргүүлнэ", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-д "Цахим дэлгүүрт байршсан бараа, үйлчилгээг бусад этгээдээс худалдан авахыг хориглоно" гэж заасантай нийцэхгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль болон Төрийн хэмнэлтийн тухай хуулийг бүрэн хэрэгжүүлж ажиллах тухай албан шаардлага хүргүүлсэн.

**Илрүүлэлт 4:** Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчийн үйл ажиллагаа тэдгээрийг чадавхжуулах арга хэмжээний хүрээнд компаниудтай шууд гэрээ байгуулан гадаадад туршлага судалснаар ямар үр дүн гарсан нь баримтаар нотлогдохгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д *"төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах"*, Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 402 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Иргэдийн төлөөлөгчдийн хурлын төлөөлөгчийн үйл ажиллагаа, тэдгээрийг чадавхжуулах арга хэмжээний зардлын нийтлэг жишиг, зарцуулах, тайлагнах журам"-ын 3.5-д *"Төлөөлөгчийг чадавхжуулах арга хэмжээг Засгийн газрын харьяа төрийн албаны сургалтын байгууллага болон холбогдох сургалтын чиглэлээр мэргэшсэн сургалтын бусад байгууллага, судлаачдын багтай хамтран зохион байгуулна"*, 4.6-д *"Ажлын алба төлөөлөгчдийн үйл ажиллагааны болон чадавхжуулах арга хэмжээний зардлын тайланг нэгтгэж, дүнг Зөвлөлийн хуралд танилцуулах бөгөөд шаардлагатай гэж үзвэл Хурлын нэгдсэн хуралдаанд танилцуулж болно"* гэж заасантай нийцэхгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 402 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Иргэдийн төлөөлөгчдийн хурлын төлөөлөгчийн үйл ажиллагаа, тэдгээрийг чадавхжуулах арга хэмжээний зардлын нийтлэг жишиг, зарцуулах, тайлагнах журам"-ын дагуу арга хэмжээний зардлын тайлан, үр дүнг тайлагнадаг байх тухай албан шаардлага хүргүүлсэн.

**Илрүүлэлт 5:** Тайлант онд 478,136.4 мянган төгрөгөөр аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгчдийг гадаад улсад туршлага судлах сургалтад хамруулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д *"төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах"*, Монгол улсын Ерөнхий сайдын 2025 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн "Төрийн албаны сахилга, дэг журам, хариуцлагыг чангатгах тухай" 03 албан даалгаврын 1.6-д *"Төрийн хэмнэлтийн тухай хуулийн дагуу төсвийн үрэлгэн байдал, хэрэгцээгүй худалдан авалт, гадаад томилолтыг хязгаарлаж, төсвийн хөрөнгөөр олон нийтийн арга хэмжээг зохион байгуулахгүй байх талаар харьяа байгууллага, хуулийн этгээдийн удирдлагад үүрэг өгч, үр дүнг тооцож ажиллах"* гэж заасантай нийцэхгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Төрийн хэмнэлтийн тухай хуулийг баримталж, төсвийн хэмнэлтийн горимыг сахин, үр ашиггүй зардал гаргахгүй байхад анхаарч ажиллах тухай албан шаардлага хүргүүлсэн.

**Илрүүлэлт 6:** Тайлант онд Бүгд Найрамдах Хятад Ард Улсад туршлага судлах 14 төлөөлөгчийн зардлыг "Гайхамшигт говь аялал жуулчлалын холбоо"-ны дансанд 92,800.0 мянган төгрөгийг 12 дугаар сарын 24-ний өдөр төвлөрүүлсэн боловч тайлант онд гүйцэтгэл гараагүй, мөн Чех улсад туршлага судлах 6 төлөөлөгчийн зардлыг 12 дугаар сарын 05-ны өдөр "Стади Энд Травел Аброад" ХХК-тай гэрээ байгуулан 47,600.0 мянган төгрөг шилжүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д *"төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах"*, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.4-д *"төсөл, арга хэмжээ төлөвлөсөн хугацаанд бүрэн хэрэгжих боломжгүй нөхцөл үүссэн тохиолдолд гэрээ байгуулах шийдвэр гаргахгүй байх"*, Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 402 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Иргэдийн төлөөлөгчдийн хурлын төлөөлөгчийн үйл ажиллагаа, тэдгээрийг чадавхжуулах арга хэмжээний зардлын нийтлэг жишиг, зарцуулах, тайлагнах журам"-ын 3.5-д *"Төлөөлөгчийг чадавхжуулах арга хэмжээг Засгийн газрын харьяа төрийн албаны сургалтын байгууллага болон холбогдох сургалтын чиглэлээр мэргэшсэн сургалтын бусад байгууллага, судлаачдын багтай хамтран зохион байгуулна"*, Монгол улсын Ерөнхий сайдын 2025 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн "Төрийн албаны сахилга, дэг журам, хариуцлагыг чангатгах тухай" 03 албан даалгаврын 1.6-д *"Төрийн хэмнэлтийн тухай хуулийн дагуу төсвийн үрэлгэн байдал, хэрэгцээгүй худалдан авалт, гадаад томилолтыг хязгаарлаж, төсвийн хөрөнгөөр олон нийтийн арга хэмжээг зохион байгуулахгүй байх талаар харьяа байгууллага, хуулийн этгээдийн удирдлагад үүрэг өгч, үр*

дүнг тооцож ажиллах", Монгол улсын Ерөнхий сайдын 2025 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн "Төсвийн сахилга бат, хариуцлагыг чангатгах" 05 албан даалгаврын 1.4.1-д "хурал, сямнар, сургалтыг цахимаар зохион байгуулж, дотоод, гадаад томилолт, тээвэр шатахуун, зочин төлөөлөгч хүлээн авах зардлыг хэмнэх" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Төрийн хэмнэлтийн тухай хуулийг баримталж, төсвийн хэмнэлтийн горимыг сахин, үр ашиггүй зардал гаргахгүй байхад анхаарч ажиллах тухай албан шаардлага хүргүүлсэн.

**Илрүүлэлт 7:** Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгчдийг гадаад улсад туршлага судлах арга хэмжээг шууд гэрээ байгуулан гүйцэтгүүлсэн, хичээл үйлдвэрлэлийн зардлыг зориулалт бусаар зарцуулж өмнөх аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагыг биелүүлээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэж заасныг хэрэгжүүлээгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Албан үүргээ биелүүлээгүй аймгийн ИТХ-ын нарийн бичгийн дарга, нягтлан бодогч нарт сахилгын хариуцлага тооцуулах тухай албан шаардлага хүргүүлсэн.

## **5.2 Зөвлөмж**

Зөвлөмж өгөөгүй болно.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруул аагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болох 3,857,329.3 мянган төгрөгийг дутуу илэрхийлсэн	1	3,857,329.3	1	3,857,329.3			1	3,857,329.3				
<b>ДҮН</b>	<b>1</b>	<b>3,857,329.3</b>	<b>1</b>	<b>3,857,329.3</b>			<b>1</b>	<b>3,857,329.3</b>				

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Үүнээс				Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
							Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Албан томилолтоор ажилласан албан хаагчдад 3,450.0 мянган төгрөгийн хоолны нэмэгдлийг давхардуулан олгосон	1	3,450.0	1	3,450.0								
Тайлант оны 2 дугаар сард албан хаагчдад илүү цагийн нэмэгдэл хөлс олгохдоо 1,157.0 мянган төгрөгөөр илүү тооцсон	1	1,156.9	1	1,156.9								
2 албан хаагчид 3,251.6 мянган төгрөгийн ээлжийн амралтын олговрыг цалинтай давхардуулан олгосон	1	3,251.6	1	3,251.6								
Хичээл үйлдвэрлэлийн зардлыг үндэслэлтэй тооцоолоогүй 444,674.1 мянган төгрөг зарцуулсан	1	444,674.1			1	444,674.1						
Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчийн үйл ажиллагаа тэдгээрийг чадавхжуулах арга хэмжээний хүрээнд компаниудтай шууд гэрээ байгуулан гадаадад туршлага судалснаар ямар үр дүн гарсан нь баримтаар нотлогдохгүй байна.	1	0			1	0						

Өмнөговь аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд хийсэн аудитын тайлан

Тайлант онд 478,136.4 мянган төгрөгөөр аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгчдийг гадаад улсад туршлага судлах сургалтад хамруулсан	1	478,136.4			1	478,136.4					
Бүгд Найрамдах Хятад Ард Улсад туршлага судлах 14 төлөөлөгчийн зардлыг "Гайхамшигт говь аялал жуулчлалын холбоо"-ны дансанд 92,800.0 мянган төгрөгийг 12 дугаар сарын 24-ний өдөр төвлөрүүлсэн боловч тайлант онд гүйцэтгэл гараагүй, мөн Чех улсад туршлага судлах 6 төлөөлөгчийн зардлыг 12 дугаар сарын 05-ны өдөр "Стади Энд Травел Абroad" ХХК-тай гэрээ байгуулан 47,600.0 мянган төгрөг шилжүүлсэн	1	140,400.0			1	140,400.0					
Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгчдийг гадаад улсад туршлага судлах арга хэмжээг шууд гэрээ байгуулан гүйцэтгүүлсэн, хичээл үйлдвэрлэлийн зардлыг зориулалт бусаар зарцуулж өмнөх аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагыг биелүүлээгүй	2	0						2	2 албан тушаалтан		
Тайлант онд 15,614.9 мянган төгрөгийн хөрөнгө бэлтгэхдээ цахим худалдан авалт хийгээгүй	1	15,614.9			1	15,614.9					
Тайлант онд хичээл үйлдвэрлэлийн зардлаас 1,395.8 мянган төгрөгийн онгоцны тасалбарын үнийг төлсөн	1	1,395.8			1	1,395.8					
<b>Дүн</b>	<b>11</b>	<b>1,088,079.7</b>	<b>3</b>	<b>7,858.5</b>	<b>6</b>	<b>1,080,221.2</b>		<b>2</b>	<b>0</b>		

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс						
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил									
<b>Дүн</b>									